

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн онцлог болон  
хөгжүүлэх талаар сургалт зохион байгууллаа

2022.4.20

Лүн

2022 оны 4-р сарын 15-ний өдөр Боловсролын тусгай хэрэгцээ шаардлагатай байгаа хүүхдүүдийн хувийн ялгаатай байдал, хэрэгцээнд тулгуурлан боловсрол эзэмшүүлэх үйл явц ба нийгэмд хүлээн зөвшөөрөгдөх мөн тэднийг ялгаварлан гадуурхалыг зогсоож тэгш хамруулалтыг бий болгох багш, эцэг эх, иргэд хамтын ажиллагааг сайжруулах, санаа бодлоо солилцох зорилгоор Засаг даргын тамгын газрын иргэний танхимд 4-р сургууль, 4-р цэцэрлэг, Засаг даргын тамгын газар нар хамтран сургалт зохион байгуулж, Л.Отгонпүрэв, Б.Золзаяа, Б.Гандиймаа нар сургалт хийж мэдээлэл өглөө.



Уг сургалтад байгууллагуудын эцэг эхийн зөвлөл, сургууль, цэцэрлэгийн эцэг эхийн зөвлөл, иргэдийн төлөөлөл гээд 35 хүн хамрагдсан ба сургалтын нээлтийг хийж Л.Гантөгс багшийн шавь нар 7-р ангийн сурагчид морин хуурийн татлага хийж, бэлтгэл бүлгийн хүүхдүүд "Цэцэрлэг минь сайн байна уу" дуугаар ая дуугаа өргөлөө.



Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн нийгмийн идэвх, оролцоог сайжруулахад эцэг эхийн хамтын ажиллагаа чухал гэдгийг сануулсан үр дүнтэй сайхан сургалт болсонд эцэг эхийн зөвлөлүүд багш нартаа талархал илэрхийлснээр сургалт өндөрлөв.



Тус сургалтын үеэр Аймгийн эрүүл мэндийн газраас баг ирж Баянтал суманд эрүүл мэндийн үйлчилгээ авахад тулгамдаж байгаа асуудлаар нээлттэй хэлэлцүүлэг хийж ард иргэдийн сэтгэгдлийг сонслоо.



Нийгмийн бодлогын мэргэжилтэн

Э.Буянтонтох